



**“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ” ТӨСЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**



БАТЛАН
ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын багцын төсөл

“Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төсөл

EUR 8.0 сая



2019-2022

Цэргийн төв
эмнэлэг

БНАУ-ын хөнгөлөлттэй зээл



2021

НИЙТ ХБГ

0.0 ₮



2022

ТӨСВИЙН САНАЛ

8 сая
евро

Бүрэлдэхүүн хэсгүүд:

1. Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх – 7.646 сая евро, 95,57%
2. Мэс заслын багаж, хэрэгсэл нийлүүлэх – 134.0 мянган евро, 1,67%
3. Сургалт – 220 мянган евро, 2,75%

Төслийн зорилго: Цэргийн төв эмнэлгийг өндөр хөгжилтэй орнуудын цэргийн эмнэлгийн жишигт хүрсэн Монгол Улсын тэргүүлэх клиникийн эмнэлэг болгон хөгжүүлэхийн тулд оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.

Төслийн хүрээнд хийх ажил: Цэргийн төв эмнэлгийн вакуум хагалгааны өрөөнүүд, мэс засал, ариутгалын болон судсан дотуурх эмчилгээний багаж хэрэгслэлийг шинэчлэн, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ. Төслийн хүрээнд 61 нэр төрлийн шинэ дэвшилтэт техник, технологийн эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын багажны иж бүрдлийг худалдан авахаар төлөвлөсөн.

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 23%

Нийт зээлийн ашиглалт: 599,300 евро





БАТЛАН
ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын багцын төсөл

“Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төсөл

2019

- “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төслийн дараагийн шатны төслийг 2019 онд санаачлан боловсруулж, 2019 онд “АМЕ интернэйшнл” компанитай 3 удаагийн уулзалтыг хийж, төсөлд хамруулах тоног төхөөрөмжийн саналыг боловсруулан, Батлан хамгаалах яаманд хүргүүлсэн.

2020

- Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр буюу 40.0 сая еврогийн ерөнхий хэлэлцээрийг 2019.12.20-ны өдөр соёрхон баталсан. 40.0 сая еврогийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг 2020.04.15-ны Засгийн газрын 130 дугаар тогтоолоор баталж, жагсаалтыг Австрийн талд хүргүүлсэн.
- БХЯ, “АМЕ интернэйшнл” компанитай 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр төслийн худалдан авах гэрээг байгуулсан.

2021

- БХЯ, “АМЕ интернэйшнл” компанитай байгуулсан гэрээнд 2021 оны 04 сарын 21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Төслийн зээлийн гэрээ 2021 оны 08 сарын 16-ны өдөр батлагдсанаар төслийн гэрээ хүчин төгөлдөр болсон.



ШИНЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Ангиограф /CATH LAB/:

- Зүрх судас, мэдрэлийн мэс засал, судасны мэс засалд өргөнөөр ашиглагдах ба зүрхний титэм судасны оношлогоо, эмчилгээ, тархины судасны цүлхэнгийн эмчилгээ, судас залгах, тайрах мэс засалд хэрэглэгдэнэ.

Электрофизиологийн лаборатори:

- Зүрхний хэм алдалтыг эмчлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэл.

Вакум хагалгааны өрөө - Ламинар урсгал:

•Цэргийн төв эмнэлэгт хагалгааны 9 өрөө ашиглагдаж байгаагаас 5 өрөөг вакум болгохоор төлөвлөж байна. Ламинар урсгал бүхий вакум өрөөтэй болсноор эмчлүүлэгчийн хагалгааны дараах халдварын эрсдлийг арилган, эмч, сувилагч нарын ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй нөхцлийг бүрдүүлж, үе солих, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны өрөөний стандартын шаардлагыг хангана.

Урологийн оношлогоо, эмчилгээний багаж тоног төхөөрөмж:

- Урологийн дурангийн мэс заслын иж бүрдэл;
- Чулуу бутлагч лазер /дурангийн/;
- Чулуу бутлагч аппарат.
- Мэс заслын тусламж, үйлчилгээнд бөөр, давсаг, шээлгүүрийн чулуу авах, түрүү булчирхайн хоргүй хавдар авах, давсагны ургацаг авах, шээлгүүрийн нарийсал засах, бөөрний идээт үрэвслийн эмчилгээ зэрэг урологийн орчин үеийн эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэргүүлэх чиглэл

Мэс засал,
яаралтай тусламж



Зүрх судасны
оношлогоо, эмчилгээ



Урологийн оношлогоо,
эмчилгээ



Мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл



Электрокоагуляцын
аппарат



Вакуум хагалгааны өрөө



Цахилгаан дерматом



Хэвлийн хөндийн
дурангийн мэс заслын
иж бүрдэл




Цөсний сувгийн дуран



Өвчүү нээгч цахилгаан
багаж



Ерөнхий мэс заслын
багажны иж бүрдэл



Гэмтэл, бичил мэс
заслын багажны иж
бүрдэл

Зүрх судасны оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж



Ангиограф-катетерийн
лаборатори



Электрофизиологийн
лаборатори

Зүрх судасны оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж



Зүрхний ЭХО аппарат



4D ЭХО аппарат



Унтуулгын аппарат

Урологийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл



Урологийн дургийн мэс
заслын иж бүрдэл



Чулуу бутлагч
дургийн лазерь
аппарат



Чулуу бутлагч аппарат

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ЦТЭ-ийн төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг 2021 оны 10 сараас эхлэн долоо хоног бүрийн пүрэв гаригт “АМЕ” компанийн холбогдох албан тушаалтнуудтай тоног төхөөрөмжийн техникийн уулзалтыг цахим хэлбэрээр явуулж байна.



“АМЕ интернэйшнл” ХХК нь вакуум хагалгааны өрөө, ангиографийн аппаратын суурилуулалтын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх барилгын хэмжилт, тооцоо, зургийн ажлыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгчээр Монгол Улсын “Solar Med” ХХК-ийг сонгон ажиллуулж байгаа бөгөөд тус эмнэлгийн барилгын “А” блокын 8,9 дүгээр давхар, “Б” блокын ангиографын өрөө, шүдний рентген аппаратын өрөөнүүдэд статик репорт буюу хөндлөнгийн дүгнэлт гаргуулах ажлыг дуусгасан. ШУТИС-ийн Барилга инженерийн сургуулийн лабораторийн бүрэлдэхүүн 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хэмжилтүүдийг хийж ажилласан. Ажлын тайланг хийж гүйцэтгэсэн.



ХҮЛЭЭН АВСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ /2022.01.13/

№	Барааны код	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /евро/	Нийт үнэ /евро/	Үйлдвэрлэгч	Загвар	Үйлдвэрлэгч орон
1	USS-02	4D ЭХО аппарат	ш	1	108,000.00	108,000.00	Siemens	ACUSON Juniper	Австри
2	USS-03	ЭХО аппарат	ш	1	65,000.00	65,000.00	Siemens	ACUSON NX3 ELITE	Австри
3	OTR-15	C-arm рентген аппарат	иж	1	89,000.00	89,000.00	Siemens	Cios Select	Австри
4	ICU-14	Өндөр урсгалын хүчилтөрөгчийн аппарат COVID-19	ш	6	11,900.00	71,400.00	Draeger	High flow	ХБНГУ
5	ICU-15	Цээжний хөндийн сорогч шахуурга	ш	10	4,200.00	42,000.00	Ardo	Senator low vacuum	Швейцари
6	OTR-13	Цахилгаан сорогч	ш	5	3,800.00	19,000.00	Ardo	Master	Швейцари
7	LAB-01	Бактериологийн анализатор VITEK	ш	1	63,400.00	63,400.00	BioMerieux	VITEK2 COMPACT 30 Clinical	АНУ
8	LAB-02	Цусны ариун чанарын анализатор /BacT/Alert	ш	1	50,500.00	50,500.00	BioMerieux	BacT/ALERT 3D 120	АНУ
9	DOM-01	Шүдний эмчилгээний сандал	иж	2	45,500.00	91,000.00	Cefla	Stern Weber S300	Итали
		Дүн		28		599,300.00			